

САНАМЖ

- Сурагчид харандаа, баллуур, шугам, гортиг, усан будаг, бийр, будгийн нийлүүр бэлтгэсэн байна.
- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.

- Монголчууд өнгө, дүрс, тооны бэлгэдлийг дээдлэн хүндэтгэж, амьдрал ахуйдаа хэрэглэсээр ирсэн уламжлалтай. Хөх өнгийн бэлгэдлийг сонгож дугуйлаарай.
 - Баяр цэнгэл, баатарлаг зориг, сүр жавхааг бэлгэддэг.
 - Үргэлж мөнх, үнэнч бат, тогтвортойг бэлгэддэг.
 - Хөгжил цэцэглэлт, сайн сайхан, амар амгаланг бэлгэддэг.
 - Үржин дэлгэрч, өсөн бойжих, эрдэнийн сан, баян чинээлэг бэлгэддэг.
- Улбар шар өнгийн уламжлалт нэршлийг сонгож дугуйлаарай.
 - Тэн
 - Хонд
 - Энгэсэг
 - Шунх
- Эцэг өнгийг эх өнгөтэй хольж хүү өнгө үүсгээрэй. Үүссэн хүү өнгөөр дугуй дүрсийг будаарай.



- Юмсыг хөдөлгөөнд оруулан зурахын тулд зургийн хавтгайн аль нэг дээд өнцгөөс эсрэг талын доод өнцөг рүү хандуулж ташуу чиглэлд дүрслэхийг өнцөглөсөн зохиомжийн аргаар зурах гэнэ. Өнцөглөсөн зохиомжийн аргаар зурсан зургийг сонгож дугуйлаарай.



А.



Б.




В.



Г.

- Өнгийг цайруулахын тулд цагаан өнгөтэй хольдог. Цагаан өнгийг их холивол, тухайн өнгө төдий чинээ цайрч, хөнгөн өнгө үүснэ. Зурагт дүрсэлсэн уулсын хол ойр байршил, орон зайг хүйтэн өнгийн алслалтаар будаарай.



6. Дүрслэх урлаг нь урлагийн нэг төрөл бөгөөд уран зураг, зураасан зураг, уран баримал, уран барилга, гоёл чимэглэлийн урлаг, тайз дэлгэцийн урлаг гэж ангилдаг. Зураасан зургийн бүтээлийг сонгож дугуйлаарай.



А.



Б.



В.



Г.

7. Цайвар өнгөнөөс бараан өнгө рүү хүндрүүлж дагнасан зурвас үүсгэн будах аргыг түйхий дагнаас гэдэг. Түйхий дагнаасыг гүйцээж будаарай.



8. Ямар нэг дүрсийг олон дахин давтан зурах аргаар хээ угалз зохиодог. Геометрийн дүрсийн гаралтай хээг сонгож дугуйлаарай.




А.



Б.



В.



Г.

9. Цаасаар хийсэн чимэглэлийн загварт тохирох аргыг сонгож дугуйлаарай.





- А. Цаасыг туузан хэлбэрээр хайчлаад, хуйлж, наах аргаар хийсэн.
- Б. Цаасыг сэтэлж хайчлаад, холбож наах аргаар хийсэн.
- В. Цаасыг дугуй хэлбэр үүсгэн хайчлаад, давхарлан наах аргаар хийсэн.
- Г. Цаасыг хэлбэр үүсгэн нугалж, бүрдэл хэсгийг нэмэх аргаар хийсэн.


10. Сурагч нимгэн картон цаасыг хуйлж ирмэгээр нь зөрүүлэн наах аргаар конус хэлбэртэй төрсөн өдрийн малгай хийжээ. Гортиг ашиглан сурагчийн хийсэн төрсөн өдрийн малгайны дэлгээсийг зураарай.



11. Аливаа эд юмс нь нэг ба хэд хэдэн хэсгүүдээс бүрддэг. Тэрхүү хэсгүүдийг эд юмсын бүрдэл хэсэг гэж нэрлэдэг. Дараах автомашины загварын бүрдэл хэсгийн хэлбэрийг өөрчлөх аргаар шинэ загвар зохиож зураарай.



12. Зургийн хавтгай дээр дүрүүдийг байрлуулах олон арга байдгийн нэг нь задгай зохиомжийн арга юм. Гол ба туслах дүр гэж ялгадаггүй, дүрүүдийг зургийн хавтгайн бүх талбайд тараан дүрсэлдэг нь энэ аргын онцлог юм.
Задгай зохиомжийн аргаар **“Миний найзууд”** сэдэвт зураг зурж, будаарай.





Засалтын хүснэгт

Даалгаврын дугаар	Авсан оноо
I	
II	
III	
IV	
V	
VI	
VII	
VIII	
IX	
X	
XI	
XII	